



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/299

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар  
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг  
балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,190,000.00 (гурван сая нэг зуун ерэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар цэцэрлэгт хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар цэцэрлэг (Б.Мягмарсүрэн)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар цэцэрлэг (Н.Хоролмаа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*В.Оюумаа*

В.ОЮУМАА



1150501005

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 10/27 дугаар тушаалын хавсралт

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 105-р цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт-анд орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
						нэгж үнэ	/ тегрөгөөр / нийт үнэ			
1	1-р хоолны тогоо	2019	сайн	ш	1	2,530,000.00	2,530,000.00	2,530,000.00	-	Сонгино хайрхан дүүргийн 106-р цэцэрлэг
2	Угаалтуур	2018	сайн	ш	1	660,000.00	660,000.00	660,000.00	-	
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн							3,190,000.00	3,190,000.00		